# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

## 2021 оны 3 дугаар сар

**Ерөнхий тойм:** Энэ оны эхний 3 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 60%-иар буюу 1,327 сая ам.доллараар өсч 3,524 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 93%-иар буюу 965 сая ам.доллараар, импорт 31%-иар буюу 362 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 602 сая ам.доллараар өсч 477 сая ам.долларын ашигтай гарлаа.

**Хүснэгт 1.** Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | Жилээр | | | Эхний 3 сар | | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2021/2020 | |
| | 2018 | 2019 | 2020 | 2019 | 2020 | 2021 | Дүн | Хувь |
| **Эргэлт** | **12,887** | **13,747** | **12,870** | **3,057** | **2,197** | **3,524** | **1,327** | **60%** |
| Экспорт | 7,012 | 7,620 | 7,576 | 1,772 | 1,036 | 2,000 | 965 | 93% |
| Импорт | 5,875 | 6,128 | 5,294 | 1,286 | 1,162 | 1,524 | 362 | 31% |
| **Тэнцэл** | **1,137** | **1,492** | **2,282** | **486** | **(126)** | **477** | **602** | |

**Зураг 1.** Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/




**Зураг 2.** Экспортын бүтэц, 2021 оны 3 дугаар сар




**Зураг 3.** Импортын бүтэц, 2021 оны 3 дугаар сар




**Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.*

*** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.*

**Экспорт:** 2021 оны эхний 3 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 93%-иар буюу 965 сая ам.доллараар өсч 2,000 сая ам.долларт хүрсэн. Экспорт ийнхүү өсөхөд уул уурхай бүтээгдэхүүний экспортын өсөлт голлон нөлөөлөв. Тодруулбал, нийт экспорт 93%-иар өсөхөд 80 нэгж хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, 11 нэгж хувийг аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өсөлт тус тус бүрдүүлж байна.

**Хүснэгт 2.** Экспортын гүйцэтгэл, эхний 3 сар /сая ам.доллар/

| Төрөл | 2019 | | | 2020 | | | 2021 | | | Δ (2021/2020) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Дүн | Өсөлт | %² |
| **1. Уул уурхай** | | **1,663** | **94%** | | **965** | **93%** | | **1,793** | **90%** | **828** | **86%** | **80%** |
| 1.1. Зэсийн хүдэр, баяжмал | 361 | 504 | 28% | 307 | 351 | 34% | 316 | 621 | 31% | 270 | 77% | *26%* |
| 1.2. Чулуун нүүрс | 7,733 | 642 | 36% | 3,122 | 252 | 24% | 6,672 | 689 | 34% | 436 | 1.7x | *42%* |
| 1.3. Боловсруулаагүй нефть | 1,621 | 88 | 5% | 322 | 18 | 2% | 1,422 | 78 | 4% | 61 | 3.4x | *6%* |
| 1.4. Төмрийн хүдэр, баяжмал | 2,072 | 107 | 6% | 2,062 | 141 | 14% | 1,913 | 239 | 12% | 97 | 69% | *9%* |
| 1.5. Мөнгөжөөгүй алт /кг/ | 4,665 | 196 | 11% | 1,556 | 80 | 8% | 443 | 26 | 1% | (55) | -68% | *-5%* |
| 1.6. Цайрын хүдэр, баяжмал | 44 | 63 | 4% | 37 | 48 | 5% | 31 | 46 | 2% | (2) | -4% | *0%* |
| 1.7. Жонш, лейцит, нефелинт | 111 | 41 | 2% | 137 | 35 | 3% | 194 | 43 | 2% | 7 | 21% | *1%* |
| 1.8. Молибдений хүдэр, баяжмал | 1 | 12 | 1% | 2 | 11 | 1% | 2 | 12 | 1% | 1 | 6% | *0%* |
| 1.9. Гянтболдын хүдэр, баяжмал | 0 | 1 | 0% | 0 | 0 | 0% | 0 | 1 | 0% | 1 | 28x | *0%* |
| 1.10. Мөнгө /тонн/ | 0 | - | 0% | 13 | 9 | 1% | 767 | 18 | 1% | 9 | 0% | *1%* |
| 1.11. Бусад | 75 | 12 | 1% | 25 | 18 | 2% | 108 | 21 | 1% | 2 | 13% | *0%* |
| **2. Мал аж, ахуй** | 111 | **43** | **2%** | 82 | **28** | **3%** | 46 | **48** | **2%** | **21** | **74%** | **2%** |
| 2.1. Амьд мал, малын мах | 7 | 14 | 1% | 1 | 2 | 0% | 5 | 9 | 0% | 8 | 4x | *1%* |
| 2.2. Арьс, шир | 98 | 4 | 0% | 78 | 4 | 0% | 35 | 2 | 0% | (2) | -46% | *0%* |
| 2.3. Малын өлөн гэдэс | 0 | 2 | 0% | 0 | 2 | 0% | 0 | 4 | 0% | 2 | 72% | *0%* |
| 2.4. Ноолуур | 2 | 15 | 1% | 2 | 17 | 2% | 2 | 28 | 1% | 11 | 62% | *1%* |
| 2.5. Ноос, бусад үс, хялгас | 3 | 7 | 0% | 2 | 2 | 0% | 3 | 4 | 0% | 2 | 97% | *0%* |
| 2.6. Бусад | 1 | 0 | 0% | 0 | 0 | 0% | 0 | 0 | 0% | 0 | 3x | *0%* |
| **3. Газар тариалан** | 13 | **3** | **0%** | 9 | **3** | **0%** | 6 | **3** | **0%** | **(0)** | **-15%** | **0%** |
| **4. Аж үйлдвэрлэл** | 118 | **62** | **4%** | 47 | **39** | **4%** | 63 | **156** | **8%** | **117** | **3x** | **11%** |
| 4.1. Хүнс | 7 | 18 | 1% | 2 | 5 | 1% | 20 | 84 | 4% | 79 | 15x | *8%* |
| 4.2. Ноолууран эдлэл | 0 | 8 | 0% | 0 | 4 | 0% | 0 | 2 | 0% | (1) | -32% | *0%* |
| 4.3. Бусад хувцас, гутал, эдлэл | 1 | 2 | 0% | 1 | 3 | 0% | 0 | 1 | 0% | (1) | -47% | *0%* |
| 4.4. Уул уурхай | 36 | 27 | 2% | 6 | 20 | 2% | 37 | 38 | 2% | 18 | 93% | *2%* |
| 4.5. Цахилгаан, электрон бараа | 0 | 0 | 0% | 0 | 0 | 0% | 0 | 0 | 0% | (0) | -74% | *0%* |
| 4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги | 0 | 5 | 0% | 1 | 7 | 1% | 0 | 28 | 1% | 22 | 3x | *2%* |
| 4.7. Бусад | 74 | 1 | 0% | 38 | 1 | 0% | 5 | 1 | 0% | 0 | 4% | *0%* |
| **5. Бусад** | 0 | **0** | **0%** | 0 | **0** | **0%** | 0 | **0** | **0%** | **(0)** | **-17%** | **0%** |
| **Нийт дүн** | | **1,772** | | | **1,036** | | | **2,000** | | **965** | **93%** | |

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал:

1/ Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 402 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 426 сая ам.доллараар тус тус өссөн.

2/ Хүнсний бүтээгдэхүүний экспортоос хамаарч Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт 117 сая ам.доллараар өссөн байна. Тодруулбал, хушны самрын экспорт өссөн байна.

**Хүснэгт 3.** Экспортын өөрчлөлт, 2021 оны эхний 3 сар

| Төрөл | Тоо хэмжээний өөрчлөлт | % | Үнийн өөрчлөлт | % | Нийт өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|
| **1. Уул уурхай** | **402** | | **426** | | **828** |
| 1.1. Зэсийн хүдэр, баяжмал | 19 | 7% | 251 | 93% | 270 |
| 1.2. Чулуун нүүрс | 366 | 84% | 70 | 16% | 436 |
| 1.3. Боловсруулаагүй нефть | 61 | 1x | 0 | 0% | 61 |
| 1.4. Төмрийн хүдэр, баяжмал | (19) | -19% | 116 | 1.2x | 97 |
| 1.5. Мөнгөжөөгүй алт /кг/ | (65) | 1.2x | 10 | -18% | (55) |
| 1.6. Цайрын хүдэр, баяжмал | (9) | 4.7x | 7 | 3.7x | (2) |
| 1.7. Жонш, лейцит, нефелинт | 13 | 1.7x | (5) | -70% | 7 |
| 1.8. Молибдений хүдэр, баяжмал | 0 | 33% | 0 | 67% | 1 |
| 1.11. Бусад | 16 | | (14) | | 2 |
| **2. Мал аж, ахуй** | **17** | 83% | **4** | 17% | **21** |
| 2.1. Амьд мал, малын мах | 8 | 1.1x | (1) | -11% | 8 |
| 2.2. Арьс, шир | (3) | 1.4x | 1 | -40% | (2) |
| 2.4. Ноолуур | 7 | 69% | 3 | 31% | 11 |
| **3. Газар тариалан** | **(1)** | **2.5x** | **1** | **1.5x** | **(0)** |
| **4. Аж үйлдвэрлэл** | **80** | **69%** | **37** | **31%** | **117** |
| **5. Бусад** | **0** | **-7%** | **0** | **-12%** | **(0)** |
| **Нийт дүн** | **498** | | **467** | | **965** |

** Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.*

**Импорт:** 2021 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 31%-иар буюу 362 сая ам.доллараар өсч 1,524 сая ам.долларт хүрсэн.

Импортын 31 хувийн өсөлтийг ерөнхий ангиллаар авч үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 15 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 11 нэгж хувийг, аж үйлдвэрийн орцын импортын өсөлт 6 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

**Хүснэгт 4.** Импортын гүйцэтгэл, эхний 3 сар /сая ам.доллар/

| Төрөл | 2019 | | | 2020 | | | 2021 | | | Δ (2021/2020) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Дүн | Өсөлт | %² |
| **Хэрэглээний бүтээгдэхүүн** | | **351** | **27%** | | **317** | **27%** | | **446** | **29%** | **129** | **41%** | **11%** |
| Түргэн эдэлгээтэй | 179 | 170 | 13% | 195 | 175 | 15% | 265 | 252 | 17% | 77 | 44% | 7% |
| *Хүнс* | *84* | 120 | *9%* | *84* | 119 | *10%* | *125* | 180 | *12%* | *62* | *52%* | *5%* |
| *Эм, тариа* | *1* | 20 | *2%* | *1* | 24 | *2%* | *1* | 33 | *2%* | *9* | *37%* | *1%* |
| *Бусад түргэн эдэлгээтэй бараа* | *94* | 30 | *2%* | *110* | 32 | *3%* | *140* | 39 | *3%* | *6* | *20%* | *1%* |
| Удаан эдэлгээтэй | 67 | 181 | 14% | *53* | 142 | 12% | *111* | 194 | 13% | 52 | 36% | *4%* |
| *Гутал, хувцас, цүнх* | *16* | 14 | *1%* | *23* | 15 | *1%* | *40* | 20 | *1%* | *5* | *32%* | *0%* |
| *Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга* | *37* | 23 | *2%* | *13* | 22 | *2%* | *38* | 31 | *2%* | *8* | *37%* | *1%* |
| *Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл* | *0* | 126 | *10%* | *0* | 87 | *7%* | *1* | 114 | *7%* | *27* | *31%* | *2%* |
| *Бусад удаан эдэлгээтэй бараа* | *13* | 18 | *1%* | *16* | 18 | *2%* | *33* | 29 | *2%* | *11* | *63%* | *1%* |
| **Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн** | *300* | **519** | **40%** | *289* | **461** | **40%** | *529* | **634** | **42%** | **173** | **38%** | **15%** |
| Машин, механик тоног төхөөрөмж, эд анги | 6 | 375 | 29% | 6 | 323 | 28% | 10 | 469 | 31% | 146 | 45% | 13% |
| *Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги* | 1 | 125 | *10%* | 2 | 106 | *9%* | 3 | 244 | *16%* | *138* | *2.3x* | *12%* |
| *Машин механик, тоног төхөөрөмж, эд анги* | 5 | 249 | *19%* | 5 | 217 | *19%* | 6 | 225 | *15%* | *8* | *4%* | *1%* |
| Барилгын материал | 138 | 104 | 8% | 138 | 97 | 8% | 158 | 107 | 7% | 10 | 10% | 1% |
| Хөрөнгө оруулалтын бусад бараа | 5 | 41 | 3% | 5 | 41 | 3% | 15 | 58 | 4% | 17 | 43% | 1% |
| **Аж үйлдвэрлэлийн орц** | 439 | **147** | **11%** | 375 | **143** | **12%** | 447 | **210** | **14%** | **66** | **46%** | **6%** |
| Хүнсний орц | 8 | 4 | 0% | 15 | 6 | 1% | 220 | 63 | 4% | 56 | 9.7x | 5% |
| Химийн бүтээгдэхүүн | 48 | 24 | 2% | 45 | 23 | 2% | 37 | 26 | 2% | 3 | 12% | 0% |
| Даавуу, утас, арьс, савхин эдлэл | 19 | 7 | 1% | 21 | 7 | 1% | 23 | 6 | 0% | (0) | -2% | 0% |
| Цахилгаан эрчим хүч | 0 | 37 | 3% | 0 | 38 | 3% | 0 | 41 | 3% | 3 | 9% | 0% |
| Металлын хүдэр, баяжмал болон хаягдал | 0 | 0 | 0% | 0 | 0 | 0% | 1 | 0 | 0% | 0 | 3.5x | 0% |
| Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай | 226 | 74 | 6% | 207 | 69 | 6% | 247 | 73 | 5% | 4 | 6% | 0% |
| **Нефтийн бүтээгдэхүүн** | **439** | **267** | **21%** | **375** | **239** | **21%** | **447** | **230** | **15%** | **(9)** | **-4%** | **-1%** |
| Дизель түлш | 263 | 163 | 13% | 200 | 125 | 11% | 274 | 136 | 9% | 11 | 8% | 1% |
| АИ-92, АИ-95 | 126 | 69 | 5% | 102 | 63 | 5% | 101 | 50 | 3% | (13) | -21% | -1% |
| А-80 болон бусад | 50 | 35 | 3% | 72 | 50 | 4% | 72 | 44 | 3% | (6) | -12% | -1% |
| **Бусад** | **2** | **2** | **0%** | **2** | **1** | **0%** | **60** | **4** | **0%** | **3** | **3.5x** | **0%** |
| **Нийт дүн** | | **1,286** | | | **1,162** | | | **1,524** | | **362** | **31%** | |

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

2021 оны эхний 3 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт импорт 362 сая ам.доллараар өссөн. Үүнд:

- Машин, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн буюу механик тоног төхөөрөмжийн импорт 173 сая ам.доллараар;
- Хэрэглээний бүтээгдэхүүний импорт 129 сая ам.доллараар;
- Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 66 сая ам.доллараар тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 9 сая ам.доллараар буурсан байна.

**Хүснэгт 5.** Импортын өөрчлөлт, 2021 оны эхний 3 сар / сая ам.доллар/

| Төрөл* | Тоо хэмжээний өөрчлөлт | % | Үнийн өөрчлөлт | % | Нийт өөрчлөлт | % |
|---|---|---|---|---|---|---|
| **Хэрэглээний бүтээгдэхүүн** | **144** | **1.1x** | **(16)** | **-12%** | **129** | **41%** |
| **Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн** | **170** | **98%** | **3** | **2%** | **173** | **38%** |
| **Аж үйлдвэрлэлийн орц** | **67** | **1x** | **(1)** | **-1%** | **66** | **46%** |
| **Нефтийн бүтээгдэхүүн** | **36** | | **(44)** | | **(9)** | **-4%** |
| Дизель түлш | 36 | 3x | (26) | 2.5x | 11 | 8% |
| АИ-92, АИ-95 | (1) | 5% | (13) | 95% | (13) | -21% |
| А-80 болон бусад | (0) | 2% | (6) | 98% | (6) | -12% |
| **Бусад** | **4** | 1.4x | **(1)** | -46% | **3** | **3.5x** |
| **Нийт дүн** | **421** | **116%** | **(59)** | **-16%** | **362** | **31%** |

** Ижил зориулалттай болович харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.*